

ОРЧИН ҮЕИЙН ИДЕАЛИЗМЫН ЭПИСТЕМОЛОГИ УТГА

Түлхүүр үг: идеализм, эпистемологийн идеализм, оюун ухаан, санаа, универсали, танин мэдэхүй.

Юуны өмнө философийн үндсэн асуудлыг тодорхойлсон Ф.Энгельсийн үзлийг дурдъя. Тэрээр: "Бүх философийн, ялангуяа шинэхэн философийн аугаа их үндсэн асуудал бол сэтгэхүй ахуйд харьцах тухай асуудал юм. Философичид энэ асуултанд хэрхэн хариулснаараа хоёр том лагерь болон хуваагджээ. Байгалиас өмнө оюун ухаан байсан гэж хэлэгчид, ингэхлээр ертөнцийг зохиомол гэж чухамдаа хүлээгчид идеалист лагерь болсон... Байгалийг анхдагч гэж зөвшөөрөн хүлээгчид материализмын янз бүрийн чиглэлд багтжээ"¹ гэж бичжээ.

"Ерөөс философийн олон янзын бүх чиглэл, урсгал нь эцсийн бүлэгт эсвэл материализм, эсвэл идеализмд хамран нийлдэг"² хэмээн марксист-ленинист философид сурталчилж иржээ.

Танин мэдэхүйн онолын чиглэлүүдийг хуваан ангилах асуудалтай тулгарахад Энгельсийн дээрх томъёоллын үүднээс материализм, идеализмын аль нэгэн лагерьт хамруулж болохгүй байна. Харин тухайн онолд юуг үндсэн асуудал болгон тавьсныг суурь болгон үзвэл эпистемологийн түүхэн эволюцийн явцад түүний үзэл сургуулиудыг ялгаж буй үндсэн асуудал, сэдвүүд нь өөрчлөгдөж иржээ. Тухайлбал: Сонгодог фундаментализмд мэдлэгийн эх сурвалжийн асуудал үндсэн асуудал байдаг бөгөөд эл асуудлаар эмпирицизм, рационализм гэсэн хоёр чиглэл байсныг бид мэднэ.

Танин мэдэхүй, түүний объект хоёрын харилцааны асуудлыг авч үздэг эпистемологи чиглэлүүдийг идеализм ба реализм хэмээн хуваадаг. Гэтэл эпистемологийн бусад чиглэлүүдэд дээрх асуудал захад гарч өөр бусад асуудал үндсэн болж тавигддаг юм. Тухайлбал эпистемологийн аналитик чиглэлд танин мэдэхүйн нэр томъёонуудын утгын асуудал чухал байдаг бол

¹ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол, 3-р боть, 411 дэх тал

прагматик чиглэлд мадаггүй танин мэдэхүйн шалгуурын асуудал чухал болон хувирдаг.

Уламжлалаар бол гносеологийн идеализм гэдгийн дор мэдлэгийн объект нь туршлага дахь мэдрэхүйн үйл явцаас эсвэл танин мэдэхүйн үйл явцаас хамаардаг гэж үздэг үзлийг³ ойлгодог. Гэтэл үүнд янз бүрээр интерпретаци /утга оноож/ хийж болно. Тухайлбал танин мэдэгч тусгаар субъект нь тусгаар объектыг нөхцөлдүүлдэг эсвэл ямар нэг тусгаар объект нь танин мэдэхүйн үйл явцын үр дүнд үүсдэг гэсэн тайлбарлал байдаг. Мөн бүх бодит байдал бол уг чанараараа туршлагын бүтээгдхүүн мөн гэж тайлбарлах нь ч бий. Ихэнхи идеалистуудын хувьд бодит байдал нь объект болон түүний талаархи мэдлэгийг өөртөө багтаахдаа харилцан холбоотой дотоод нэгдэлтэй системийг бүрдүүлдэг.

Идеалист танин мэдэхүйн онолын философийн үндэс нь эртний үеэс /античный/ эхтэй юм. Тухайлбал пифагорчуудын үзэл нь бидний мэдлэг бол субъектив юм гэж хэлэхээс нэлээд хол байсан боловч бодит байдлын эх үндэс нь оюун ухаанаар танигдан мэдэгдэж байгаа тоон дараалал мөн гэдэг. Энэ санаа нь Платоны сургаальд нэлээд боловсронгуй болж “ертөнц бол оюун ухаанаар танигдан мэдэгдэж байдаг санаануудын ноёрхол мөн” гэсэн хэллэг болсон. Хэдийгээр Аристотель үүний эсрэг байр суурьтай байсан боловч эл үзэл нь дундад зууны үеийн философи сэтгэлгээнд хүчтэй нөлөө үзүүлсэн билээ.

Идеализмд өгөгдмөл байдаг гол шинж бол субъективизм мөн. Субъективизмийн үзлээр объект бол зөвхөн дан рациональ танин мэдэхүйн өгөгдхүүн төдий биш мөн интеллектын үйл ажиллагаанаас хамаарч байдаг. Декартын **cogito ergo sum** хэмээх хэллэг нь субъективизмыг орчин үеийн танин мэдэхүйн онолын тулгын чулуу болгон хувиргасан юм. Дж.Берклигийн: “esse est percipi” - “to be (real) is to be perceived” – “оршино гэдэг бол мэдрэгдэнэ гэсэн үг” гэсэн алдарт хэллэгийг субъектив идеалист үзэл гэхээс биш онтологи утгаар интерпретаци хийж болохгүй юм. Берклигээс хойшхи идеалист үзлийг эрс /хатуу/, эрс биш /зөөлөн/ хэмээн хоёр хэсэгт хувааж болохоор байдаг юм. Эрс идеалист үзэлтнүүд юмс, оршихуй гэдэг бол зарим субъектэд үнэхээр ялгарч, ижилсэж, мэдрэгдэж (discriminated, identified, perceived), мэдэгдэнэ /discerned/ гэсэн үг. Гэтэл эрс биш идеалист үзэл нь

² Марксист-Ленинист философийн үндсүүд. УБ., 1982 он. 11 дэх тал

аливаа бодит юм бол зарчмын хувьд зарим субъектэд мэдэгдэх ёстой, байгаль нь танин мэдэхүйд орох ёстой хэмээн тайлбарладаг.

Кант нэг талаас бидний интуици ба категориуд нөгөө талаас бидэнд хүртээлгүй юм /things-in-themselves- вещь в себе/ хоёрын хооронд нийлж болохгүй зааг ялгаа байдаг гэсэн. Гегелийн үеэс германы идеалистууд оюун ухаан хэмээх ойлголтыг бүх бодит байдлын үндэс мөн гэж үзэж эхэлснээс болж идеализмын уламжлал германд уналтанд орж улмаар идеализм нь Англи, Америкад нүүн суурьшиж сэргэхдээ дан танин мэдэхүйн онолын хүрээнд яригдах болсон юм. Энэ чиглэлийн гол төлөөлөгчид бол Брэдли, Бозанкет, Ройс, Блэншард, Хокинг, Коген, Наторп, Виндельбанд, Риккерт, Дилтей, Кроче, Кассирер, Коллингвуд гэх мэт болно.

Идеализм гэдэг бол бодит байдал нь ямар нэгэн байдлаар оюун ухаантай холбоотой, эсвэл оюун ухаантай харьцмал байдаг гэх буюу гадаад ертөнцийг бүрдүүлэгч бодит объектууд нь танин мэдэгч оюун ухаанаас хамааралгүй биш, сэтгэхүйн үйлдлүүдтэй харилцах замаар оршдог гэж үздэг философийн номлол юм¹. Өөрөөр хэлбэл бодит байдал гэдэг бол оюун ухаан тусгаж, ажиллаж, ойлгож байгаа тэр зүйл мөн гэдэг үзэл дээр анхаарлаа хандуулдаг номлол юм.

Олон зууны туршид идеалист лагерийн хүрээн дэх маргааны бай нь "оюун ухаан" байсан бөгөөд тэр нь байгалиас гадна, түүний цаана байрладаг гэдэг абсолют идеализм, зарим рациональ зүйл нь байгальд дэлгэрсэн хүч мөн гэх космик идеализм, бие хүнээс гаднах хамтын нийгмийн оюун ухаан мөн гэх социаль идеализм, хувь хүмүүсийн оюун ухааны дистрибутив нэгдэл мөн гэх персональ идеализм гэх мэтийн олон хувилбаруудыг нэрлэж болох юм. Эдгээрээс хамгийн радикаль нь эртний ориентал спиритуалистуудын үзэл болон панпсихик үзэл юм. Тэд оршин байгаа бүх юм бол оюун ухаан болон сэтгэхүй мөн, бодит зүйл бол нэг болон олон оюун ухааны үзлийн нийлбэр төдий зүйл юм гэж үздэг.

Орчин үеийн эпистемологийн идеалист үзлийн олон хувилбаруудыг дараах байдлаар төрөлжүүлж² болох юм. Үүнд:

³ Т.И.Хилль. Современные теории познания /пер с англ. М.:1965. С 35.

¹ The Cambridge Dictionary of Philosophy / edited by Robert Audi. -2nd edition 1999. p 412.

² A Companion To Epistemology / edited by Jonathan Dancy and Ernest Sosa. 1997. p 187-188

- (I) Баримтын идеализм – Баримт бол хэлээр хэлбэрчлэгдэн илэрхийлэгддэг, ингэж байж л үнэн байдаг. Аливаа баримт бол семантикийн хувьд /хэлний утгаар/ хүлэгдсэн хэлэнд хэлбэрчлэгдсэн үнэн мөн хэмээдэг үзэл юм.
- (II) Когнитив идеализм - Үнэн гэдэг бол танигдан мэдэгдсэн зүйл мөн. Аливаа үнэн бол мэдлэгийн нэг хэсэг болох хувьдаа танин мэдэхүйгээр хүлэгдсэн байдаг. Үнэн бол оюун ухааны танин мэдэх бололцоотой хамт гарч ирдэг.
- (III) Тайлбарлагч идеализм – Физик бодит байдал болон байгалийг адекват /тохируулж/ тайлбарлана гэдэг бол тайлбарлалын уг агуулгын хүрээнд сэтгэхүйн үйлдэл, тоочилт хийх зарим боломжийг шаарддаг гэж үздэг.
- (IV) Концептуаль идеализм – Бодит байдал бол оюун ухааны категориудын нэр томъёогоор л ойлгогддог, бодит байдлын талаархи бидний мэдлэг бол зөвхөн оюун ухаанаар хангагдан баригдсан зүйл төдийгүй үнэндээ зарим хэмжээгээр оногдхууны /референт/ оюуны загвар мөн. Баримтын талаархи бидний мэдлэг бол түүний оршин байгаа нөхцөл байдлыг хүн тусган бий болгосон зүйл мөн. Тэр нь оюун ухаанаар бүтээгдсэн, оюун ухааныг ашиглан хийгдсэн ойлголтуудыг хэрэглэн хэлбэрждэг. Бидний эзэмшиж байгаа аливаа мэдлэг бол түүний оногдхууныг оюун ухаанд бүтээгдсэн нэр томъёонуудаар хэлбэрждэг.

Дээр бүх өгүүлснээс мөрдөн үзвэл марксизмд үздэгчлэн "ухамсар оюун санаа анхдагч, матери хоёрдогч гэж үздэг хүмүүсийг идеалистууд" гэдэг тодорхойлолтын арга зүй энд ажиллахгүй байгаа юм.

Идеализм бол бодит байдлыг үгүйсгэдэг, түүнд сөргөөр ханддаг үзэл мөн хэмээн буруутгадаг зарим үзэл сургаалын тухайд асуудлыг гажуудуулан тайлбарладаг юм. Энд асуудлын бай нь экзистенци /оршихуй/ биш харин бодит байдлын уг чанарын тухай асуудал юм. Тухайлбал Беркли материаллаг объектуудын экзистенцийг үгүйсгэсэн хэрэг биш харин тэдгээрийн мэдрэхүйд өртөхгүй байдлыг үгүйсгэсэн юм. Идеализм бол зарим философи сургаальд тайлбарладагчлан оюун ухаан нь материйг бүтээдэг, тогтоодог гэж үздэг үзэл биш, харин физик оршихуйг тодорхойлогч бүх шинж чанарууд нь илэрхий байдлаар оюун ухаанаар хангагдан дүрслэгддэг

мэдрэхүйн шинж чанаруудтай адил, иймд тэдгээр шинж чанарууд нь оюун ухаанд хандахгүйгээр бололцоогүй хэмээн үздэг үзэл юм. Иймээс ч тайлбарлагч идеализм дахь бодит байдлыг адекват тайлбарлах гэдэг нь оюун ухааны тодорхой үйлдлүүдийг шаарддаг юм.

Орчин үеийн идеализмын аливаа хувилбарт нийтлэг байдаг дараах зүйлсүүдийг онцолж болох юм. Үүнд:

1. Универсалийн асуудал. Сонгодог уламжлалын хүрээнд үүсэн Кантын нөлөөг авсан XX зууны ихэнхи идеалист сэтгэгчид танин мэдэхүй бол универсалийг хэрэглэхтэй холбоотой гэж үздэг. Тухайлбал Америкийн философич Блэншард /1892-1987/: “Оюун ухаан эхлэх хамгийн эхний моментоос л универсалийг хэрэглэж эхэлдэг”¹, эцсийн дүндээ универсали л бидний танин мэдэхүйн цорын ганц объект мөн хэмээн тодорхойлжээ. Ойлголтын агуулгыг тогтоогч универсали нь танин мэдэхүйн үйл явцад ямагт оролцдог психологийн биш шинжтэй юм.

2. Санааны онол. Санааны асуудлаархи зангилаа асуудал бол санаа гэж юу болох? тэр нь хэрхэн үүсдэг тухай асуудал биш, харин санаа нь өөрийн объекттой хэрхэн харьцдаг тухай асуудал юм. Эл асуудлын хариулт нь танин мэдэгч ба танигдан мэдэгдэгчийн харилцааны асуудлын түлхүүр болох юм. Сонгодог эмпиризмд санаа бол өөрийн объекттойгоо төстэй дүр мөн гэдэг. Санаа нь дүртэй холбоотой үүсдэг боловч санаа болон дүр нь бие биенээсээ үл хамааран өөрчлөгддөг, харин ерөнхий санааны дүр гэж ерөөс байж болохгүй¹ юм.

3. Үнэний асуудал. Аливаа үнэн бол зайлшгүй мөн бөгөөд ерөөс танин мэдэхүйд нэг л систем үйлчилдэг гэсэн санаа өнөө үед улам хүчтэй болсон. Математик бодомжууд нь эмпирик биш боловч зайлшгүй, бусад шинжлэх ухаанууд ч гэсэн ихэнх нь цэвэр индуктив биш, гипотетик-дедуктив байгууламжтай гэсэн дүгнэлтийг өнөөдөр бараг бүх философичид хүлээн зөвшөөрч буй юм. Иймд өндөр хөгжсөн онолууд нь туршлагад хандсан, бие биетэйгээ дедуктив харилцаатай концептуаль схемүүд байдаг. Ингэхлээр хэрэв нэг хэсгийн тухай мэдэж чадвал бусад хэсгийн талаар дедуктив гаргалгаагаар мэдэж болох, баримттай яг гарцаагүйгээр тохирох нь боломжгүй байсан ч концептуаль схем өөрчлөгдөөгүй тохиолдолд дедуктив

¹ Bradley. The Principles of Logic. // Т.И.Хилль. Современные теории познания /пер с англ. М.:1965. С 39.

харилцаа хадгалагдсаар байх юм. Ийм зайлшгүй системийн үйлчлэх хүрээ маш өргөн учраас ердийн эргэцүүлэлд ч энгийн логик харилцаанууд үйлчилдэг, иймд зайлшгүй харилцаануудын олонлог нь бидний хэлний илэрхий биш хэлбэр болдог.

Резюме

Затрагивая вопросы классификации современных эпистемологических учений по их основным вопросам, автор в своей статье уделяет особое внимание эпистемологическому идеализму. При этом автор различает его от онтологического идеализма в классической философии. На основе этого автор формулирует свое определение понятия "эпистемологический идеализм". А также важное место в статье занимают вопросы об основных вариантах современного эпистемологического идеализма, таких, в первую очередь, как идеализм факта, когнитивный идеализм, интерпретирующий идеализм и концептуальный идеализм.

¹ Blanshard. The Nature of Thought.// Т.И.Хилль. Современные теории познания /пер с англ. М.:1965. С 69.